

## ТАНИЛЦУУЛГА

АНУ-ын Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр баталсан "Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц" 1947 оны 4 дүгээр сарын 4-ний өдрөөс хүчин төгөлдөр болж, Монгол Улс тус конвенцэд 1989 оны 9 дүгээр сарын 7-ны өдөр нэгдэн орж, Олон улсын иргэний нисэхийн байгууллагын гишүүн улс болсоноор тус байгууллагын бодлого, чиглэлийн дагуу олон улсын стандарт, шаардлагад нийцсэн иргэний нисэхийн тогтолцоо бүрдүүлэх, салбарыг хөгжүүлэх, дэлхийн агаарын харилцаанд бусад гишүүн улс орны адил эрх тэгш оролцох боломж бүрдсэн.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 206 дугаар хуралдааны үеэр Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд заасан Агаарын навигацийн комиссын гишүүний тоо 19 байгааг 23 болгон нэмэгдүүлж, конвенцэд өөрчлөлт оруулах тухай саналыг Болив, Буркино Фасо, Камерун, Чили, Доминикан, Египет, Энэтхэг, Кени, Лив, Никарагуа, Нигери, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират, Танзани, Венесуэл Улсууд дэвшүүлснийг Канад Улсын Монреаль хотноо 2016 онд зохион байгуулсан Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 39 дэх Ассамблейн чуулганаар хэлэлцэн тус конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах Протоколоор Агаарын навигацийн комиссын гишүүдийн тоог 21 болгон нэмэгдүүлсэн.

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 56 дугаар зүйлд "Агаарын навигацийн комисс Хэлэлцэн тохирогч улсуудаас нэр дэвшүүлсэн хүмүүсийн дотроос Зөвлөл томилсон 19 гишүүнээс бүрдэнэ. Эдгээр хүмүүс нь агаарын тээврийн салбарын шинжлэх ухаан, практик ажлын зохих туршлага, мэргэшилтэй байна. Зөвлөл хэлэлцэн тохиролцогч улсуудад нэр дэвшүүлэх хүсэлт тавина. Агаарын навигацийн комиссын даргыг Зөвлөл томилно" гэж заасан.

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 57 дугаар зүйлд зааснаар Олон улсын иргэний нисэхийн байгууллагын Агаарын навигацийн комисс нь дараах үүрэгтэй:

- Конвенцын Хавсралттай холбоотой асуудлыг хэлэлцэх, Зөвлөлөөр батлуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;
- Техникийн дэд комиссуудыг байгуулах;
- Агаарын навигацийн дэвшилд шаардлагатай бөгөөд тустай гэж үзсэн мэдээг цуглуулах, Хэлэлцэн тохирогч улсуудад хүргүүлэх талаар Зөвлөлд мэдэгдэх.

Дэлхийн агаарын тээврийн тэргүүлэгч орнууд болох ОХУ, БНХАУ-ын дунд байрлалтай манай улсын нутаг дэвсгэр дээгүүр Ази, Европ тивийг холбосон хамгийн дөт агаарын зам дамжин өнгөрч байна.

Далайд гарцгүй манай орны хувьд агаарын тээвэр нь гуравдагч оронтой богино хугацаанд шууд холбогдох онц чухал ач холбогдолтой салбар бөгөөд Олон улсын иргэний нисэхийн байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцсоноор бус нутгийн агаарын навигацийн гол түшиц орон зайд болох, олон улсын нисэх буудлын ашиглалтыг сайжруулах, агаарын тээвэр өргөжин хөгжихэд ач холбогдолтой юм.

Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцын 94 дүгээр зүйлд зааснаар конвенцэд оруулсан аливаа өөрчлөлт нийт гишүүн орнуудын гуравны хоёр нь соёрхон баталсан тохиолдолд хүчин төгөлдөр болно. Туунчлэн дээрх Протоколын 3 дугаар зүйлийн 3 (d) хэсэгт зааснаар уг протокол хүчин төгөлдөр болоход нийт 128

гишүүн орон соёрхон баталсан байх шаардлагатай бөгөөд одоогоор 60 орон нэгдэж, соёрхон баталсан тухай батламжийг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад хүргүүлээд байна.

Монгол Улс тус протоколд нэгдэн орсноор Олон улсын иргэний нисэхийн байгууллагад бодлого, стандарт боловсруулах үндсэн бүтцэд өргөн хүрээний төлөөлөл бий болгох үйл ажиллагаанд өөрийн орны хувь нэмрийг оруулах, Монгол Улсын мэргэшсэн хүний нөөцийг Агаарын навигацийн комиссын бүрэлдэхүүнд ажиллуулах боломж бүрдэх юм.

Олон улсын гэрээний тухай хуулийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны Чикагогийн конвенцын 56 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах Протоколд нэгдэн орох тухай асуудлыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн дэмжсэн болно.

#### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР